



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠙᠙᠑ оны ᠐7 сарын ᠐1 өдөр

Дугаар А/᠑᠙᠑

Мандалговь

“Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжье”  
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.2 дахь заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар бүлгийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжье” аяны удирдамжийг 1 дүгээр, аяны үр дүнг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аяныг сум, байгууллагын хэмжээнд өрнүүлэн, сар бүр аяны явцыг дүгнэж, 9 дугаар сарын 1-нд явцын тайланг, 12 дугаар сарын 01-нд нэгдсэн тайланг ажлын хэсэгт ирүүлэхийг сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. “Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжье” аяны урамшуулалд шаардагдах 3500000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111052